

Аудитын код: САГ-2018/12/СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Цэрэндорж
Утас: 261740 Цахим хаяг: tserendorjd@audit.gov.mn

Аудитор Ц.Энхжаргал
Утас: 261740 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан.....	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	2
2.5	Дотоод хяналт	2
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	4
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	4
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.9.1	Авлагын талаар.....	4
2.9.2	Эргэн төлөгдөх зээлийн талаар	4
2.9.3	Буцалтгүй тусламжийн талаар	5
2.9.4	Зээлийн чөлөөлөлтийн талаар.....	5
2.9.5	Эргэн төлөгдөх зээлийн талаар	6
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	6
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	6
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	6
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	6
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3	Менежментийн захидал	8
3.1	Буцалтгүй тусламжийн талаар	9
3.2	Зээлийн чөлөөлөлтийн талаар.....	10
3.3	Зээлийн эргэн төлөлтийн талаар	11
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	12
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
5	Аудитын хураангуй тайлангийн хавсралт	20



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН
САНГИЙН ЗАХИРАЛ
П.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

2018.03.23 № 06/820
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Боловсролын зээлийн сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Боловсролын зээлийн сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Боловсролын зээлийн сангийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2018\0323SAG23.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

071471

Аудитын гол асуудал

Боловсролын зээлийн сангийн санхүүгийн тайланд

- 150,211.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй,
- Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад магистр, докторын сургалтын эргэн төлөгдөх зээл 37,292.2 сая төгрөг,
- Дэлхийн шилдэг сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцагчдын эргэн төлөгдөх зээл 13,610.3 сая төгрөг,
- Буцалтгүй тусламжийн 4,837.0 сая төгрөгийн зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

Боловсролын зээлийн сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Боловсролын зээлийн сангийн захирал П.Лхагвасүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн буцалтгүй тусламж, зээлийн чөлөөлөлт, эргэн төлөгдөх зээлийн талаарх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Боловсролын зээлийн сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.


Боловсролын зээлийн сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 26-наас 2018 оны 3 дугаар сарын 02-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, Боловсролын зээлийн сангийн захиралд хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэндорж, аудитор Ц.Энхжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар Боловсролын зээлийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Боловсролын зээлийн сангийн 2018 оны 1 дүгээр сарын 25-нд ирүүлсэн байна.



2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Боловсролын зээлийн сан нь санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”, “Эдийн засгийн ангилал батлах тухай” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.13, 6 дугаар зүйлийн 6.4.6, 16 дугаар зүйлийн 16.4, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 9.3 дахь заалтыг үндэслэн Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолоор Сургалтын төрийн санг “Боловсролын зээлийн сан” болгон өөрчлөн зохион байгуулсан байна.

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайд, Сангийн сайдын 2016 оны А/78/351 дүгээр тушаалаар Боловсролын зээлийн сангийн орон тооны хязгаарыг 23 орон тоотойгоор баталсан байна.

Боловсролын зээлийн сангийн зорилго нь дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид зохих журмын дагуу санхүүгийн дэмжлэг, суралцагчийн тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл олгох, зээлийг эргэн төлүүлэх ажлыг зохион байгуулах зорилгын хүрээнд ажиллана.

Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг гол шалгуур болголоо.

Аудитаар Боловсролын зээлийн сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 10 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 17 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/


Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Боловсролын зээлийн сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Боловсролын зээлийн сан нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа



гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох тухай Засгийн газрын 2014 оны 71, 2011 оны 102, 2016 оны 111 дүгээр тогтоолуудын хэрэгжилттэй холбогдуулан төрийн өмчийн болон төрийн өмчийн бус хэвшлийн нийт 14 сургуулийн 4468 суралцагчдын санхүүгийн тооцоо, анхан шатны баримтад шалгалт хийсэн байна.

Боловсролын зээлийн сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалтгүй гэж үзлээ.

Дотоод аудитын алба байхгүй, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлууд давтан илэрч байна.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар Боловсролын зээлийн сан 10 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж урсгал зардалд дээрх хуулиар 85,120.0 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 45,311.9 сая төгрөг буюу 46.8 хувьтай байгаа нь 39,314.7 сая төгрөгийн оюутны хөгжлийн зээл олгогдоогүйтэй холбоотой байна. Оюутны хөгжлийн зээлийн хүү, барьцаа хөрөнгийн асуудал, арилжааны банкны тавигдах шалгуур зэргээс шалтгаалан 2016 онд 2,806.2 сая төгрөгийн санхүүжилтийг авч, 2017 онд 2,353 суралцагчдад 4,806.2 сая төгрөгийн зээлийг олгосон байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан бөгөөд улсын төсвийн санхүүжилт 41,052.4 сая төгрөгөөр дутуу санхүүжигдэн, зээлээс 1,608.9 сая төгрөг эргэн төлөгдөж, 610.8 сая төгрөгийн бусад орлого, 142.2 сая төгрөгийн ханшийн орлоготой ажилласан байна.

Урсгал шилжүүлэг 347.6 сая төгрөг буюу 1.6 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 90.3 сая төгрөг буюу 4.8 дахин, эд хогшил худалдан авах 10.2 сая төгрөг буюу 5.3 дахин хэтрүүлэн зарцуулжээ.

Үндсэн цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 1.7 сая төгрөг буюу 0.7 хувиар, томилолт, зочны зардал 0.9 сая төгрөг буюу 64.8 хувиар, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 0.3 сая төгрөг буюу 1.1 хувиар тус тус хэмнэгдсэн байна.

2017 онд 19,332 суралцагчдад 21,690.8 сая төгрөгийн буцалтгүй тусламж, тэтгэлгийг олгосон байна. Хүснэгтээр харуулбал:

№	Үзүүлэлт	Суралцагч /тоо/	Олгосон нийт зардал /сая төгрөг/
1	Дотоодын их, дээд сургуулиудад суралцагчдын буцалтгүй тусламж	5,839	12,796.8
2	Орон нутгаас суралцаж буй оюутнуудын замын зардлын хөнгөлөлт	10,981	1,033.4
3	Засгийн газрын гэрээгээр гадаадаас дотоодод суралцагчдад олгох тэтгэмж	122	667.5
4	Багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудад олгох сургалтын төлбөр	1,517	4,835.8
5	Орон нутагт хийх багшлах дадлагын тэтгэлэг	104	327.1
6	Засгийн газар хоорондын тэтгэлгээр гадаадад суралцагчдад олгох тэтгэмж	151	2,030.2
	Нийт дүн	19,312	21,690.8

2017 онд гадаад болон дотоодын дээд боловсролын байгууллагын 2,723 суралцагчдад 22,704.1 сая төгрөгийн сургалтын төлбөрийн зээлийг олгосон байна.

№	Үзүүлэлт	Суралцагч /тоо/	Олгосон нийт зардал	
			мянган ам.доллар	сая төгрөг
1	Дотоодын дээд боловсролын байгууллагад суралцагчдад	2,353	-	2,000.0
2	Гадаадын дээд боловсролын байгууллагын магистрантур, докторантур	175	2,586.2	6,342.1
3	Дэлхийн шилдэг их сургуулийн бакалавр	195	5,885.9	14,362.1
	Нийт дүн	2,723	8,472.1	22,704.1

2.7 Шилэн дансны мэдээлэл

Боловсролын зээлийн сан нь Шилэн дансны тухай хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн төсөв, гүйцэтгэл, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, санхүүжилт, бараа, ажил үйлчилгээ худалдан авсан нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр хаяг мэдээллийг болон худалдан авах ажиллагааны тайлан, жилийн эцэс, хагас жилийн санхүүгийн тайланг оруулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр, нийт 19 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Авлагын талаар

2017 оны жилийн эцсийн байдлаар 150,211.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “тасралтгүй”, 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах ...” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, авлагын дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж тооцоо нийлж, актаар баталгаажуулах талаар албан шаардлага хүргүүлэх;

2.9.2 Эргэн төлөгдөх зээлийн талаар

Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад магистр, докторын сургалтыг 1486 төгсөгч дүүргэсэн ба 555 төгсөгчийн сургалтын зээлийн төлбөр 15,364,723 ам.долларын буюу 37,292.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Төгсөж ирээд бүртгүүлсэн 504 төгсөгчөөс ажил эрхлэлтийн бүртгэл тодорхойгүй 173 төгсөгчийн 4,917,130 ам.доллар буюу 11,934.5 сая төгрөг,
- Ажил эрхлэлтийн бүртгэл, мэдээлэл шинэчлэгдээгүй 115 төгсөгчийн 3,780,594 ам.доллар буюу 9,176.0 сая төгрөг,
- Сургуулиа төгссөн боловч бүртгүүлээгүй 267 төгсөгчийн 6,666,999 ам.доллар буюу 16,181.7 сая төгрөгийн сургалтын зээлийн эргэн төлөлтийн гэрээ хэрэгжээгүй байна.

Дэлхийн шилдэг сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцсан 58 төгсөгчөөс 40 төгсөгчийн сургалтын төлбөр 5,607,555.1 ам. доллар буюу 13,610.3 сая төгрөгийг санхүүжүүлснээс гэрээ нь хэрэгжээгүй байна. Үүнд:

- Ажил, хөдөлмөр эрхлээгүй 4 төгсөгчийн сургалтын төлбөр 925,454 ам.доллар буюу 2,246.2 сая төгрөг,
- Сургуулиа төгссөн боловч бүртгүүлээгүй 36 төгсөгчийн сургалтын төлбөр 4,682,101.1 ам.доллар буюу 11,364.1 сая төгрөг байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ...”,

Гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх тухай гэрээний 3.5-д “Их сургуулиа төгсөж ирсэн даруйдаа энэ тухай Сургалтын төрийн санд ирж мэдэгдэнэ”, 3.6-д “Төгсөгч ... зээлийн эргэн төлөх хуваарь гарган ... эргэн төлнө”,

Дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцах оюутанд зээл олгох, эргэн төлүүлэх гэрээний 3.6-д “Их сургуулиа төгсөж эх орондоо ирснээс хойш ажлын 21 хоногийн дотор Сургалтын төрийн санд өөрийн биеэр ирж мэдэгдэнэ” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх тухай гэрээ, дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцах оюутанд зээл олгох, эргэн төлүүлэх гэрээний заалтуудыг биелүүлэн, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж барагдуулах ажлыг зохион байгуулах талаар албан шаардлага хүргүүлэх;

2.9.3 Буцалтгүй тусламжийн талаар

2017 оны жилийн эцсийн байдлаар буцалтгүй тусламжид 12,796.8 сая, өндөр онооны тэтгэлэгт 4,835.8 сая, нийт 17,632.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон ба 4,837.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:


- Элсэлтийн ерөнхий шалгалтад өндөр оноо авсан суралцагчдын төлбөрийг 4 жилээр санхүүжүүлж, голч оноог харгалзан сургалтын төлбөрөөс чөлөөлөх нарийвчилсан журамгүйгээр 4,835.8 сая төгрөгийн сургалтын төлбөрийг олгосон,
- Буцалтгүй тусламжийн дүн, зорилтот хөтөлбөрийн бүртгэлийн програмын дүнгээс 1.2 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “тасралтгүй”, 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-т “үнэн зөв байх”, Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтад “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”-ын 4-т Сургалтын төлбөр болон амьжиргааны зардал 4.1.5-д “... элсэлтийн ерөнхий шалгалтад 650-750 оноо авсан бол сургалтын төлбөрийн 70 хувь, 751-ээс дээш оноо авсан бол сургалтын төлбөрийг 100 хувь” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, буцалтгүй тусламжийн бүртгэлийг баталгаажуулах, өндөр онооны тэтгэлэг олгох талаар нарийвчилсан заалтыг боловсруулж шийдвэрлүүлэх зөвлөмж хүргүүлэх;

2.9.4 Зээлийн чөлөөлөлтийн талаар

2017 онд гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцсан 51 төгсөгчийн 1,376,814 ам.доллар буюу 3,341.7 сая төгрөгийн сургалтын зээлийг Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийн дагуу Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайдын 2017 оны А/88 дугаар тушаалаар чөлөөлсөн байна.



Энэ нь Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8-д “Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг Улсын Их Хурал тогтооно”,

Гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх тухай гэрээний 3.5-д “Их сургуулиа төгсөж ирсэн даруйдаа энэ тухай Сургалтын төрийн санд ирж мэдэгдэнэ”, 3.6-д “Төгсөгч ... зээлийн эргэн төлөх хуваарь гарган ... эргэн төлнө”,

Дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцах оюутанд зээл олгох, эргэн төлүүлэх гэрээний 3.7-д “Төгсөгч зээлийг эргэн төлөхтэй холбогдох харилцааг Дээд боловсролын санхүүжилт, суралцагчийн нийгмийн баталгааны тухай хуулийн 8.8-д заасан журмаар зохицуулна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийг хэрэгжүүлж, гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх тухай гэрээ, дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцах оюутанд зээл олгох, эргэн төлүүлэх гэрээний заалтыг мөрдөж ажиллах, талаар зөвлөмж хүргүүлэх,

2.9.5 Эргэн төлөгдөх зээлийн талаар

Сургалтын төлбөрийн зээлийг олгохдоо бакалаврын хөтөлбөрт сургуулиас ирүүлсэн нэхэмжлэхээр, магистр, докторын хөтөлбөрт 16,000 ам.долларын сургалтын зээл, амьжиргааны зардлыг олгодог ба амьжиргааны зардлыг тогтоосон эрх зүйн акт тодорхойгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолын 2-т “Сургалтын зээл нь сургалтын төлбөр байна” гэж өөрчлөх; 2013 оны 271 дүгээр тогтоолын 1.2 дахь хэсэгт “...гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад магистр, докторын зэргийн боловсрол эзэмшихээр ...”, 2012 оны 19 дүгээр тогтоолын 4 дүгээр 1.3-т “... гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2014 оны 19 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх;

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД


Боловсролын зээлийн сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар оюутны хөгжлийн зээл, сургалтын зээлийн эргэн төлөлтийг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Боловсролын зээлийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 209,292.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 201,113.8 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 8,178.7 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Боловсролын зээлийн сангийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 4 зөвлөмж, 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн зардлын аудитаар 9 зөвлөмж өгөгдсөн ба эдгээрээс тус бүр 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.



2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Боловсролын зээлийн сангийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 24,916.4 сая төгрөг бөгөөд 1.0 хувиар буюу 24.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Боловсролын зээлийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Боловсролын зээлийн сангийн санхүүгийн тайланд:

- 150,211,3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй,
- Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад магистр, докторын сургалтын эргэн төлөгдөх зээл 37,292.2 сая төгрөг,
- Дэлхийн шилдэг сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцагчдын эргэн төлөгдөх зээл 13,610.3 сая төгрөг,
- Буцалтгүй тусламжийн 4,837.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Энэ нь УСНББОУС болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна.

Иймд дээр дурдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Боловсролын зээлийн сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Хязгаарлалттай” санал дүгнэлт гаргалаа.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Боловсролын зээлийн сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 Буцалтгүй тусламжийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

2017 оны жилийн эцсийн байдлаар буцалтгүй тусламжид 12,796.8 сая, өндөр онооны тэтгэлэгт 4,835.8 сая, нийт 17,632.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон ба 4,837.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Элсэлтийн ерөнхий шалгалтад өндөр оноо авсан суралцагчдын төлбөрийг 4 жилээр санхүүжүүлж, голч оноог харгалзан сургалтын төлбөрөөс чөлөөлөх нарийвчилсан журамгүйгээр 4,835.8 сая төгрөгийн сургалтын төлбөрийг олгосон,
- Буцалтгүй тусламжийн дүн, зорилтод хөтөлбөрийн бүртгэлийн програмын дүнгээс 1.2 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “тасралтгүй”, 5.1.3-т “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-т “үнэн зөв байх”, Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтад “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”-ын 4-т Сургалтын төлбөр болон амьжиргааны зардал 4.1.5-д “... элсэлтийн ерөнхий шалгалтад 650-750 оноо авсан бол сургалтын төлбөрийн 70 хувь, 751-ээс дээш оноо авсан бол сургалтын төлбөрийг 100 хувь” гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, үргүй зардал гарах, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх үүрэг батламж мэдэгдлүүд зөрчигдөх;

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, буцалтгүй тусламжийн бүртгэлийг баталгаажуулах, өндөр онооны тэтгэлэг олгох талаар нарийвчилсан заалтыг боловсруулж шийдвэрлүүлэх;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.2 Зээлийн чөлөөлөлтийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

2017 онд гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцсан 51 төгсөгчийн 1,376,814 ам.доллар буюу 3,341.7 сая төгрөгийн сургалтын зээлийг Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийн дагуу Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайдын 2017 оны А/88 дугаар тушаалаар чөлөөлсөн байна.

Энэ нь Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8-д “Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг Улсын Их Хурал тогтооно”,

Гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх тухай гэрээний 3.5-д “Их сургуулиа төгсөж ирсэн даруйдаа энэ тухай Сургалтын төрийн санд ирж мэдэгдэнэ”, 3.6-д “Төгсөгч ... зээлийн эргэн төлөх хуваарь гарган ... эргэн төлнө”,

Дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцах оюутанд зээл олгох, эргэн төлүүлэх гэрээний 3.7-д “Төгсөгч зээлийг эргэн төлөхтэй холбогдох харилцааг Дээд боловсролын санхүүжилт, суралцагчийн нийгмийн баталгааны тухай хуулийн 8.8-д заасан журмаар зохицуулна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдэл зөрчигдөх;

ҮАГ-ын зөвлөмж

Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийг хэрэгжүүлж, гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх тухай, дэлхийн шилдэг их сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцах оюутанд зээл олгох, эргэн төлүүлэх гэрээний заалтыг мөрдөж ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



3.3 Зээлийн эргэн төлөлтийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Сургалтын төлбөрийн зээлийг олгоходоо бакалаврын хөтөлбөрт сургуулиас ирүүлсэн нэхэмжлэхээр, магистр, докторын хөтөлбөрт 16,000 ам.долларын сургалтын зээл, амьжиргааны зардлыг олгодог ба амьжиргааны зардлыг тогтоосон эрх зүйн акт тодорхойгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолын 2-т “Сургалтын зээл нь сургалтын төлбөр байна” гэж өөрчлөх; 2013 оны 271 дүгээр тогтоолын 1.2 дахь хэсэгт “...гадаад орны дээд боловсролын сургалтын байгууллагад магистр, докторын зэргийн боловсрол эзэмшихээр ...”, 2012 оны 19 дүгээр тогтоолын 4 дүгээр 1.3-т “... гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдэл зөрчигдөх;

ҮАГ-ын зөвлөмж

Засгийн газрын 2014 оны 19 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.




4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	139,619,420,834.50	157,421,668,859.53
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	39,782,689.40	103,631,169.61
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	39,782,689.40	103,631,169.61
3121	Төгрөг	39,782,689.40	103,631,169.61
31211	Төрийн сангийн харилцах	39,782,689.40	103,631,169.61
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	8,000,000,000.00	7,099,995,789.96
321	Үнэт цаас	8,000,000,000.00	7,099,995,789.96
32110	Төгрөг	8,000,000,000.00	7,099,995,789.96
33	АВЛАГА	131,579,638,145.10	150,211,329,299.96
33400	Зээлийн хүүгийн авлага	-	2,553,306.10
335	Бусад авлага	131,579,638,145.10	150,208,775,993.86
3351	Байгууллагаас авах авлага	131,579,638,145.10	150,208,775,993.86
34	УРЬДЧИЛГАА	-	5,123,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	5,123,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	-	1,589,600.00
354	Хангамжийн материал	-	1,589,600.00
35410	Бичиг хэргийн материал	-	1,589,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	109,712,095.81	137,432,531.62
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	109,712,095.81	137,432,531.62
392	Биет хөрөнгө	109,712,095.81	67,172,918.28
39203	Авто-тээврийн хэрэгсэл	49,800,000.00	49,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(26,614,575.42)	(34,914,575.46)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	126,385,330.50	99,014,361.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(86,491,218.60)	(73,557,553.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	87,474,201.86	51,357,295.86
39208	Хуримтлагдсан элэгдэл	(40,841,642.53)	(24,526,610.29)
393	Биет бус хөрөнгө	-	70,259,613.34
39301	Програм хангамж	66,790,000.00	140,320,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(66,790,000.00)	(70,060,586.66)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	139,729,132,930.31	157,559,101,391.15
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	960,240,162.08	32,148.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	960,240,162.08	32,148.00
413	Өглөг	960,240,162.08	32,148.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	32,148.00
4136	Бусад өглөг	960,240,162.08	-
41361	Байгууллагад төлөх өглөг	920,457,472.68	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	39,782,689.40	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	138,768,892,768.23	157,559,069,243.15
51	Засгийн газрын хувь оролцоо	138,768,892,768.23	157,559,069,243.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	29,809,531.00	29,809,531.00
51101	Өмч: - төрийн	29,809,531.00	29,809,531.00
512	Хуримтлагдсан үр дүн	138,739,083,237.23	157,529,259,712.15
51210	Өмнөх үеийн үр дүн	138,739,083,237.23	135,197,124,124.23
51220	Тайлант үеийн үр дүн	-	22,332,135,587.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	139,729,132,930.31	157,559,101,391.15



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	146,174,579,735.87	47,336,570,289.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,301,369.83	1,154,993,073.53
120	Нийтлэг татварын бус орлого	6,301,369.83	1,154,993,073.53
120002	Хүүгийн орлого	6,301,369.83	158,833,124.35
120009	Бусад орлого	-	996,159,949.18
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	146,168,278,366.04	46,181,577,216.43
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	146,098,143,306.68	46,122,643,721.11
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	146,098,143,306.68	46,122,643,721.11
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65,645,159.36	52,547,816.32
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	65,645,159.36	52,547,816.32
1330	Төсвийн захирагчдаас	4,489,900.00	-
133003	Хөрөнгийн	4,489,900.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	6,385,679.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	6,385,679.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	116,294,840,496.53	24,916,394,460.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	116,294,840,496.53	24,916,394,460.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	263,578,484.28	360,725,685.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	174,216,682.00	248,315,732.98
210101	Үндсэн цалин	174,216,682.00	248,315,732.98
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,325,884.00	27,713,817.00
210201	Тэтгэврийн даатгал	12,329,567.00	17,950,467.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,409,093.00	2,171,829.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,746,007.00	2,236,198.00
210204	Ажилгүйдлийн даатгал	349,202.00	486,848.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,492,015.00	4,868,475.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,979,410.25	11,346,286.11
210401	Бичиг хэрэг	3,962,150.00	1,984,600.00
210402	Тээвэр, шатахуун	3,888,500.00	1,366,000.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	7,045,060.25	6,734,751.57
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,083,700.00	1,260,934.54
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	882,500.00	1,723,000.00
210604	Урсгал засвар	882,500.00	1,723,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,500,300.00	470,100.00
210702	Дотоод албан томилолт	2,500,300.00	470,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,349,520.00	16,357,704.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,349,520.00	10,226,004.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		6,131,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,324,188.03	54,799,045.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		4,230,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40,324,188.03	50,569,045.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	116,031,262,012.25	24,555,668,774.78
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,204,367,283.92	21,973,388,995.74
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж,	203,412,000.00	275,966,000.00

	урамшуулал		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	58,000,955,283.92	21,690,822,995.74
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	6,600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	57,826,894,728.33	2,582,279,779.04
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	57,826,894,728.33	2,582,279,779.04
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>29,879,739,239.34</u>	<u>22,420,175,829.85</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	459,111,266.60	147,679,208.25
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	459,111,266.60	147,679,208.25
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	436,916,340.48	235,719,450.17
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	82,773,200.73
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	152,948,363.17	152,946,249.44
230001	Эргэж төлөгдөх зээл	283,967,977.31	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	22,194,926.12	(88,040,241.92)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>29,901,934,165.46</u>	<u>22,332,135,587.92</u>



4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	29,809,531.00	108,837,149,071.78	108,866,958,602.78
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,809,531.00	108,837,149,071.78	108,866,958,602.78
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			
Тайлант үеийн үр дүн		29,901,934,165.45	29,901,934,165.45
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	29,809,531.00	138,739,083,237.23	138,768,892,768.23
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	29,809,531.00	138,739,083,237.23	138,768,892,768.23
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-3,541,959,113.00	-3,541,959,113.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,809,531.00	135,197,124,124.23	135,226,933,655.23
Тайлант үеийн үр дүн		22,332,135,587.92	22,332,135,587.92
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	29,809,531.00	157,529,259,712.15	157,559,069,243.15




4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	147,115,408,696.45	48,348,719,742.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,015,288,902.77	610,761,299.43
120	Нийтлэг татварын бус орлого	1,015,288,902.77	610,761,299.43
120002	Хүүгийн орлого	6,301,369.83	156,279,818.25
120009	Бусад орлого/ нэр данс зөрүү/	1,008,987,532.94	454,481,481.18
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	146,100,119,793.68	47,737,958,443.33
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	146,098,143,306.68	47,731,529,244.33
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	146,098,143,306.68	46,122,643,721.11
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-	1,608,885,523.22
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,976,487.00	6,429,199.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,976,487.00	6,429,199.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	116,252,330,607.08	25,460,580,159.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	116,252,330,607.08	25,460,580,159.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	221,068,594.83	320,878,777.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	176,610,364.57	248,327,102.43
210101	Үндсэн цалин	163,127,764.57	225,803,302.43
210102	Нэмэгдэл	-	13,180,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,482,600.00	9,343,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,236,400.00	27,713,819.55
210201	Тэтгэврийн даатгал	19,236,400.00	27,713,819.55
2104	Хангамж, бараа материалын зардал	16,979,410.26	22,057,051.57
210401	Бичиг хэрэг	3,962,150.00	7,104,300.00
210402	Тээвэр, шатахуун	3,888,500.00	6,222,200.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	7,045,060.26	8,267,751.57
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,083,700.00	462,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	882,500.00	1,723,000.00
210604	Урсгал засвар	882,500.00	1,723,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,500,300.00	470,100.00
210702	Дотоод албан томилолт	2,500,300.00	470,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,859,620.00	16,357,704.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,859,620.00	10,226,004.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	6,131,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,230,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,230,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	116,031,262,012.25	25,139,701,382.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,204,367,283.92	21,973,388,995.74
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	203,412,000.00	275,966,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	58,000,955,283.92	21,600,822,905.74
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	6,600,000.00



2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	57,826,894,728.33	3,166,312,386.51
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	57,826,894,728.33	3,166,312,386.51
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>30,863,078,089.37</u>	<u>22,888,139,582.96</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,489,900.00	109,372,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,489,900.00	109,372,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,489,900.00	109,372,900.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	4,489,900.00	109,372,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(4,489,900.00)</u>	<u>(109,372,900.00)</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	31,347,471,075.16	22,704,155,197.54
230001	Эргэж төлөгдөх зээл	31,347,471,075.16	22,704,155,197.54
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	321,124,193.54	10,763,005.20
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	321,124,193.54	10,763,005.20
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>30,863,078,089.37</u>	<u>22,888,139,582.96</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	<u>(167,758,692.25)</u>	<u>63,848,480.21</u>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	207,541,381.65	39,782,689.40
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	39,782,689.40	103,631,169.61



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		39,782,689.40	39,782,689.40	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	85,119,967,000.00	45,311,865,827.82	(39,808,101,172.18)	53.2
УРСГАЛ ЗАРДАЛ	22,005,283,700.00	22,454,771,540.88	449,487,840.88	102.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	321,947,500.00	423,822,478.55	101,874,978.55	131.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	243,559,900.00	241,897,903.43	(1,661,996.57)	99.3
Үндсэн цалин	219,838,200.00	219,374,103.43	(464,096.57)	99.8
Нэмэгдэл	14,378,100.00	13,180,200.00	(1,197,900.00)	91.7
Унаа хоолны хөнгөлөлт	9,343,600.00	9,343,600.00	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,023,500.00	27,713,819.55	(309,680.45)	98.9
Тэтгэврийн даатгал	28,023,500.00	27,713,819.55	(309,680.45)	98.9
Хангамж, бараа материалын зардал	22,720,800.00	22,720,751.57	(48.43)	100.0
Бичиг хэрэг	7,105,500.00	7,104,300.00	(1,200.00)	100.0
Тээвэр, шатахуун	6,222,200.00	6,222,200.00	-	100.0
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	7,916,300.00	8,267,751.57	351,451.57	104.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,476,800.00	1,126,500.00	(350,300.00)	76.3
Эд хогшил, урсгал засварын зардал	2,373,700.00	12,581,000.00	10,207,300.00	530.0
Багаж, техник, хэрэгсэл		10,208,000.00	10,208,000.00	-
Урсгал засвар	2,373,700.00	2,373,000.00	(700.00)	100.0
Томилолт, зочны зардал	1,336,300.00	470,100.00	(866,200.00)	35.2
Дотоод албан томилолт	1,336,300.00	470,100.00	(866,200.00)	35.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,933,300.00	114,208,904.00	90,275,604.00	477.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,396,300.00	10,226,004.00	(170,296.00)	98.4
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,537,000.00	103,982,900.00	90,445,900.00	768.1
Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,230,000.00	4,230,000.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,230,000.00	4,230,000.00	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,683,336,200.00	22,030,949,062.33	347,612,862.33	101.6

Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	57,560,066.59	57,560,066.59	-
Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	57,560,066.59	57,560,066.59	-
Бусад урсгал шилжүүлэг	21,683,336,200.00	21,973,388,995.74	290,052,795.74	101.3
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	306,480,000.00	275,966,000.00	(30,514,000.00)	90.0
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,370,256,200.00	21,690,822,995.74	320,566,795.74	101.5
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,600,000.00	6,600,000.00	-	100.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	152,939,089.39	152,939,089.39	-
Гадаад эх үүсвэрээр	-	152,939,089.39	152,939,089.39	-
Гадаад эх үүсвэрээр		152,939,089.39	152,939,089.39	-
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	63,114,683,300.00	22,704,155,197.54	(40,410,528,102.46)	36.0
Эргэж төлөгдөх зээл	63,114,683,300.00	22,704,155,197.54	(40,410,528,102.46)	36.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	86,119,967,000.00	47,429,434,361.66	(38,690,532,638.34)	55.1
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	86,119,967,000.00	45,067,611,454.82	(41,052,355,545.18)	52.3
Улсын төсвөөс санхүүжих	86,119,967,000.00	45,067,611,454.82	(41,052,355,545.18)	52.3
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	752,937,383.62	752,937,383.62	-
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	752,937,383.62	752,937,383.62	-
БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	1,608,885,523.22	1,608,885,523.22	-
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	-	1,608,885,523.22	1,608,885,523.22	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	103,631,169.61	103,631,169.61	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	23	23	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	22	22	-	100.0



5 АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2017 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2018/12/СТА-ЗГТС
Шалгагдсан байгууллагын нэр:	Боловсролын зээлийн сан			Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2017 оны жилийн эцсийн байдлаар 150,211.3 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.	150,211.3	Албан шаардлага	Захирал	П.Лхагвасүрэн
				Ерөнхий нягтлан бодогч	А.Өнөрцэцэг
2	Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад магистр, докторын сургалтыг дүүргэсэн 555 төгсөгчийн сургалтын зээлийн төлбөр 15,364,723 ам.долларын буюу 37,292.2 сая төгрөгийг, дэлхийн шилдэг сургуулийн бакалаврын хөтөлбөрт суралцсан 40 төгсөгчийн сургалтын зээлийн төлбөр 5,607,555.1 ам.доллар буюу 13,610.3 сая төгрөгийг санхүүжүүлснээс гэрээ нь хэрэгжээгүй байна.	50,902.5	Албан шаардлага	Захирал	П.Лхагвасүрэн
				Ерөнхий нягтлан бодогч	А.Өнөрцэцэг
Нийт дүн		201,113.8			

